



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2005 оны 3 сарын 9 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолын 4 дүгээр заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг "Соёл, урлагийн газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Соёл, урлагийн газар /Ц.Пүрэвхүү/-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2001 оны 11 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БЭГЭЭД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2005 оны
9 сарын 9 ны өдрийн 78 дугаар
захирамжийн хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар \ цаашид газар гэх\ нь Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, уран сайхны боловсролыг нь дээшлүүлэх, соёл урлагийг хөгжүүлэх, соёлын өвийг хамгаалах, соёлын үнэт зүйлийг өвлүүлэн эзэмшүүлэх, тэдгээрийг сурталчилах, соёл урлагийн олон талт үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2 Газар нь зорилт үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Соёлын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд, төрөөс баримтлах соёлын бодлого, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, захирамж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3 Газар нь Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4 Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага зохион байгуулалт

2.1 Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж чөлөөлнө.

2.2 Газрын дарга нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын цалин урамшуулалыг тогтоож эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

2.3 Газрын дарга нь батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, Нийслэлийн төрийн албаны салбар зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр чөлөөлнө.

2.4 Газрын даргын дэргэд байгууллагын зорилт үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

Гурав. Газрын үүрэг

3.1 Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах.

3.2 Соёл, урлагийн талаар холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

3.3 Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон Нийслэлийн эрх зүйн байдлын тухай болон бусад хуулийг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг соёл урлагийн байгууллагуудтай өмчийн хэлбэр үл харгалзан хамтран ажиллах.

3.3.1 Харьяа болон Нийслэлийн өмчит соёл урлагийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зохиож байгаа ажлыг уялдуулж, ажил сайжруулах арга хэмжээг цаг хугацаанд нь авч байх

3.3.2 Хувийн хэвшлийн соёл урлагийн байгууллагууд, чөлөөт уран бүтээлчдэд арга зүйн зөвлөмж хүргэж, хүн амд үзүүлж байгаа үйлчилгээний хүртээмж чанарт хяналт тавих.

3.3.3 Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хүний хөгжил, соёл урлагийг хөгжүүлэх талаар өргөн хүрээтэй хамтран ажиллах.

3.4 Соёл, урлагийн байгууллагын ажилтнуудыг тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллуулах, тэдний хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулах, мэргэжил боловсролыг нь дээшлүүлж арга барилыг боловсронгуй болгохтой холбогдсон арга зүйн сургалт, семинар зохион байгуулах.

3.5 Ардын уламжлалт соёл урлаг, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх, уламжлуулах, энэ ажилд соёл урлагийн ажилтнууд, ардын авьяастнуудыг зохион байгуулалттай оролцуулах.

3.6 Нийтийг хамарсан урлаг, уран сайхны хөдөлгөөнийг бүх талаар дэмжин урлагийн наадам, уралдаан тэмцээн соёл урлагийн баяр, өдрүүдийг зохион байгуулах.

3.7 Нийслэлийн нутаг дэвсгэр дэх соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, уламжлуулахтай холбогдсон харилцааг зохицуулан зохион байгуулах.

3.8 Нийслэл хотын соёл, түүхийг сэргээн сурталчлах, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх

3.9 Нийслэл хотын гудамж талбайн чимэглэл, нийтийг хамарсан баяр ёслолын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

3.10 Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

3.11 Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

3.12 Соёл, урлагийн байгууллагуудын ажил үйлчилгээний талаар иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулах.

3.13 Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст хүргүүлж хянуулна.

Дөрөв. Газрын эрх

4.1 Соёл урлагийн ажил үйлчилгээтэй холбоотой асуудлаар албан байгууллага, хувь хүмүүст үүрэг даалгавар өгөх биелэлтийг хангуулах, мэдээ тайлан гаргуулах.

4.2 Харьяа болон нийслэлийн өмчит соёл урлагийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага албан тушаалтныг ажилд томилох, эгүүлэн татахад санал өгөх, тэдний ажлын талаар санал дүгнэлт гаргах.

4.3 Соёл урлагийн төлбөрт үйлчилгээ эрхлэхийг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд холбогдох журмын дагуу зөвшөөрөл олгон бүртгэлжүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

4.4 Соёл урлагийн талаар гадаад орны холбогдох байгууллагуудтай нийслэлийн удирдлагын зөвшөөрсөнөөр хамтран ажиллах гэрээ, хэлцэл байгуулан хэрэгжүүлэх, хамтын ажиллагаатай ах дүү хотуудаас туршлага судлах.

4.5 Харьяа болон Нийслэлийн өмчит соёл урлагийн байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг еөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх.

4.6 Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж, тайлагнах.

4.7 Төрөөс нийгмийн салбарыг хувьчлахтай холбогдуулан Нийслэлийн Соёл урлагийн байгууллагуудын хувьчлалын бэлтгэл ажил, хувьчлалын үйл

явцад хяналт тавьж, хувьчлагдсан байгууллагуудын үйл ажиллагааны чиг үүргийг сахиулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

4.8 Газар нь Нийслэлд соёл урлагийг хөгжүүлэх, дэмжих, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, олон улсын наадам, концертыг санхүүжүүлэх зорилго бүхий "Соёл, урлагийг хөгжүүлэх сан" бий болгож, ажиллах

4.9 Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн соёл урлагийн байгууллага, чөлөөт уран бүтээлчдийн зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, уран бүтээлийн тайлан тоглолт, соёл урлагийн арга хэмжээнд дүгнэлт өгөх, шаардлагатай арга хэмжээ авах

4.10. 4.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн Соёл, урлагийн газар нь Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газар, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үндэсний нийгэмлэгтэй ажил үүргийн холбоотой ажиллах

4.11 Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтыг хүн амд соёл урлагийн бодлогоор хүргэж ажиллах мэргэжлийн урлагийн байгууллагатай байх.

4.12 Соёл урлагийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан байгууллага, иргэд, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг Төр засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1 Газрын дарга ажилтнууд нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдсод холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Зургаа. Бусад зүйл.

6.1 Энэхүү дүрмэнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

6.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.